

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/193/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мөрөн сум 2023 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn аудитор: Г.Ичинхорлоо Утас: 88688168 Цахим хаяг: ich@audit.gov.mn Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн Захирал: Б.Мядагмаа Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com Аудитор Д.Оюундаваа Утас 99389692 Цахим хаяг: Oyuna_60@yahoo.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 4

Асуудлыг онцолсон хэсэг 4

Аудитын гол асуудал..... 4

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... 6

4. АУДИТЫН ТАЙЛАН 16

4.1 Ерөнхий зүйл 16

4.2 Материаллаг байдал..... 17

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт..... 17

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 17

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 17

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 18

 Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын Сод эрдэм сумын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна. 18

4.5.1 Завсрын аудитын талаар..... 18

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 18

5.3 Зөвлөмж..... 18

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БСШУС 2	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/125
танай _____-ны № _____-т

**МӨРӨН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СОД ЭРДЭМ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛД. МӨНХБААТАР
ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам”-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгө данс 48,347.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургууль нь 2022 онд “Багш бүрийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжин, суралцагчдад тулгарах бэрхшээлийг арилгах, сургалтыг зохион байгуулж байгууллагын үйлчилгээний чанарт ахиц гаргана. гэсэн зорилго дэвшүүлж 5 зорилт дэвшүүлэн гүйцэтгэлийн 85 хувьтай биелүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /Төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	137,535,159.66	188,908,041.63
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	48,347,127.36
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	48,347,127.36
3121	Төгрөг	00.00	48,347,127.36
31211	Төрийн сангийн харилцах	00.00	48,347,127.36
33	АВЛАГА	00.00	3,802,018.16
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	802,018.16
335	Бусад авлага	00.00	3,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	3,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	137,535,159.66	136,758,896.11
351	Түүхий эд материал	5,319,087.00	2,345,047.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	00.00
35130	Эм боох материал	5,319,087.00	2,345,047.00
354	Хангамжийн материал	132,216,072.66	134,413,849.11
35410	Бичиг хэргийн материал	11,661,834.55	29,839,966.41
35420	Аж ахуйн материал	14,724,190.00	18,133,000.00
35450	Барилгын засварын материал	3,247,300.00	2,793,340.00
35470	Бусад хангамжийн материал	102,582,748.11	83,647,542.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,360,933,885.18	5,352,827,822.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,360,933,885.18	5,352,827,822.88
392	Биет хөрөнгө	5,143,643,889.14	5,137,868,575.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,931,568,150.00	4,931,568,150.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-258,920,427.00	-345,542,569.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	283,708,281.43	407,063,194.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	-48,367,012.93	-101,268,554.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	183,782,337.30	216,683,096.41
39208	Хуримтлагдсан элэгдэл	-74,906,281.19	-96,659,236.85
39214	Бусад үндсэн хөрөнгө	95,410,250.00	95,410,250.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,529,799.76	-16,087,209.72
39217	Ном	40,898,391.29	46,701,455.29
393	Биет бус хөрөнгө	217,289,996.04	214,959,247.08
39301	Програм хангамж	11,653,745.00	11,653,745.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,263,748.96	-5,594,497.92
39303	Бусад биет бус хөрөнгө	208,900,000.00	208,900,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,498,469,044.84	5,541,735,864.51
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,498,469,044.84	5,541,735,864.51
51	Засгийн газрын хувь оролцоо	5,498,469,044.84	5,541,735,864.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	208,900,000.00	208,900,000.00
51101	Өмч: - төрийн	208,900,000.00	208,900,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	5,289,569,044.84	5,332,835,864.51
51210	Өмнөх үеийн үр дүн	5,162,840,491.22	5,289,569,044.84
51220	Тайлант үеийн үр дүн		43,2668819.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,498,469,044.84	5,541,735,864.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,910,177,454.34	2,236,027,038.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,220,597.79	128,725,338.44

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120	Нийтлэг татварын бус орлого	115,220,597.79	128,725,338.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	115,220,597.79	128,725,338.44
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	35,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	115,220,597.79	128,690,338.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	269,762,656.55	2,107,301,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,790,521,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,790,521,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,525,194,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,263,256.55	3,274,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,120,156.55	237,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,143,100.00	3,036,600.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	251,499,400.00	313,506,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	251,499,400.00	313,506,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,770,509,000.72	2,192,760,218.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,770,509,000.72	2,192,760,218.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,702,721,800.62	2,070,042,731.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,103,876,853.90	1,362,310,682.03
210101	Үндсэн цалин	727,321,355.00	942,282,038.40
210102	Нэмэгдэл	311,783,500.90	360,198,358.65
210104	Урамшуулал	64,771,998.00	59,830,284.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,358,301.00	170,572,461.45
210201	Тэтгэврийн даатгал	101,091,968.97	117,659,707.65
210202	Тэтгэмжийн даатгал	11,109,966.37	13,453,423.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,844,292.05	10,762,746.78
210204	Ажилгүйдлийн даатгал	2,119,278.63	3,497,628.66
210205	Эрүүл мэндийн даатгал	21,192,794.98	25,198,955.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,410,800.00	252,322,313.92
210301	Гэрэл, цахилгаан	5,840,000.00	7,000,000.00
210302	Түлш, халаалт	230,410,800.00	229,390,199.92
210303	Цэвэр, бохир ус	8,160,000.00	15,932,114.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,303,442.00	25,179,465.55
210401	Бичиг хэрэг	150,000.00	13,206,434.55
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	2,405,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	810,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	3,364,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,100.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,239,042.00	9,567,531.00
2105	Нормативт зардал	4,597,720.00	4,652,010.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,597,720.00	3,274,010.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,378,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,584,770.00	38,600,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,449,640.00	00.00
210604	Урсгал засвар	6,135,130.00	38,600,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,908,000.00	15,716,800.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,900,000.00	2,897,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	12,819,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	163,681,913.72	200,688,698.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	18,967,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,376,343.00	11,556,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	139,305,570.72	170,164,798.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,787,200.10	122,717,487.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,680,000.00	122,717,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,180,000.00	122,479,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	237,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,107,200.10	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,107,200.10	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	139,668,453.62	43,266,819.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,939,900.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	12,939,900.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-12,939,900.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	126,728,553.62	43,266,819.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,794,956,856.55	2,107,336,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,794,956,856.55	2,107,301,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,790,521,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,790,521,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,525,194,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,263,256.55	3,274,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,120,156.55	237,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,143,100.00	3,036,600.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	251,499,400.00	313,506,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	251,499,400.00	313,506,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,655,220,236.55	1,991,764,162.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,655,220,236.55	1,991,764,162.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,587,433,036.45	1,869,046,675.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,102,542,698.90	1,363,112,700.19
210101	Үндсэн цалин	725,987,200.00	943,084,056.56
210102	Нэмэгдэл	311,783,500.90	360,198,358.65

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210104	Урамшуулал	64,771,998.00	59,830,284.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,358,301.00	170,572,461.45
210201	Тэтгэврийн даатгал	101,091,968.97	117,659,707.65
210202	Тэтгэмжийн даатгал	11,109,966.37	13,453,423.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,844,292.05	10,762,746.78
210204	Ажилгүйдлийн даатгал	2,119,278.63	3,497,628.66
210205	Эрүүл мэндийн даатгал	21,192,794.98	25,198,955.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,410,800.00	252,322,313.92
210301	Гэрэл, цахилгаан	5,840,000.00	7,000,000.00
210302	Түлш, халаалт	230,410,800.00	229,390,199.92
210303	Цэвэр, бохир ус	8,160,000.00	15,932,114.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,003,096.55	00.00
210401	Бичиг хэрэг	3,885,394.55	00.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	810,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	4,565,640.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	710,062.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,532,000.00	00.00
2105	Нормативт зардал	4,219,600.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,010,300.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,209,300.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,525,240.00	16,482,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,436,640.00	00.00
210604	Урсгал засвар	7,088,600.00	16,482,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,298,000.00	15,716,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,290,000.00	2,897,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	12,819,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,075,300.00	50,840,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	31,595,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,075,300.00	19,244,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,787,200.10	122,717,487.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,680,000.00	122,717,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,180,000.00	122,479,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	237,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,107,200.10	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,107,200.10	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>139,736,620.00</u>	<u>115,572,537.36</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	139,736,620.00	67,225,410.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	139,736,620.00	67,225,410.00
2200	Дотоод эх үүсвэрээр	139,736,620.00	67,225,410.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	139,736,620.00	67,225,410.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-139,736,620.00</u>	<u>-67,225,410.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	48,347,127.36
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	48,347,127.36

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	/ төгрөгөөр /	
		Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	208,900,000.00	5,125,908,810.53	5,334,808,810.53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,900,000.00	5,125,908,810.53	5,334,808,810.53
Тайлант үеийн үр дүн	00.00	36,931,705.19	36,931,705.19
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	208,900,000.00	5,289,569,044.84	5,498,469,044.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,900,000.00	5,289,569,044.84	5,498,469,044.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	43,266,819.67	43,266,819.67
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	208,900,000.00	5,332,835,864.51	5,541,735,864.51

2.5 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	дүн	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,794,952,800.00	1,745,246,072.64	49,706,727.36	97.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,794,952,800.00	1,745,246,072.64	49,706,727.36	97.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,665,449,700.00	1,622,766,572.64	42,683,127.36	97.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,359,954,100.00	1,323,285,293.19	36,668,806.81	97.3
210101	Үндсэн цалин	1,035,209,100.00	906,984,365.56	128,224,734.44	87.6
210102	Нэмэгдэл	293,325,500.00	358,620,733.65	-65,295,233.65	122.3
210104	Урамшуулал	31,419,500.00	57,680,193.98	-26,260,693.98	183.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,994,300.00	165,698,669.45	4,295,630.55	97.5
210201	Тэтгэврийн даатгал	115,596,100.00	114,337,833.89	1,258,266.11	98.9
210202	Тэтгэмжийн даатгал	13,599,600.00	13,062,615.87	536,984.13	96.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,879,700.00	10,450,101.14	429,598.86	96.1
210204	Ажилгүйдлийн даатгал	2,719,900.00	3,420,495.35	-700,595.35	125.8
210205	Эрүүл мэндийн даатгал	27,199,000.00	24,427,623.20	2,771,376.80	89.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,225,900.00	15,716,800.00	1,509,100.00	91.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,396,200.00	2,897,400.00	1,498,800.00	65.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,829,700.00	12,819,400.00	10,300.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	118275400.00	118065810.00	209,590.00	99.8

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,030,900.00	98,821,310.00	209,590.00	99.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,244,500.00	19,244,500.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129503100.00	122479500.00	7,023,600.00	94.6
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	0.00	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00	0.00	
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	00.00	0.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	129,503,100.00	122,479,500.00	7,023,600.00	94.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	129,503,100.00	122,479,500.00	7,023,600.00	94.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,794,952,800.00	1,793,593,200.00	1,359,600.00	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,790,521,600.00	1,790,521,600.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,790,521,600.00	1,790,521,600.00	0.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,731,200.00	3,0716,00.00	1,359,600.00	100.0
1200042	Үндсэн үйл ажиллагааны ажиллагааны орлогоос санхүүжих	4,731,200.00	3,0716,00.00	1,359,600.00	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	48,347,127.36	-48,347,127.36	
65	Орон тоо	92.00	92.00	0.00	100.0
650004	Бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	68.00	68.00	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮ)	24.00	24.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

данс	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	/төгрөгөөр/	
				Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	313,506,000.00	313,505,512.92	487.08	100.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	313,506,000.00	313,505,512.92	487.08	100.00
210	Бараа, үйлчилгээний зардал	313,506,000.00	313,505,512.92	487.08	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,827,500.00	39,827,407.00	93.00	100.00
210101	Үндсэн цалин	36,099,700.00	36,099,691.00	9.00	100.00
210102	Нэмэгдэл	1,577,700.00	1,577,625.00	75.00	100.00
210104	Урамшуулал	2,150,100.00	2,150,091.00	9.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,874,100.00	4,873,792.00	308.00	99.99
210201	Тэтгэврийн даатгал	3,321,900.00	3,321,873.76	26.24	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	390,900.00	390,807.17	92.83	99.98
210203	ҮОМШӨ ний даатгал	312,700.00	312,645.64	54.36	99.98
210204	Ажилгүйдлийн даатгал	77,200.00	77,133.31	66.69	99.91
210205	Эрүүл мэндийн даатгал	771,400.00	771,332.12	67.88	99.99

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	252,322,400.00	252,322,313.92	86.08	100.00
210301	Гэрэл цахилгаан	7,000,000.00	7,000,000.00	0.00	100.00
210302	Түлш, халаалт	229,390,200.00	229,390,199.92	0.08	100.00
210303	Цэвэр, бохир ус	15,932,200.00	15,932,114.00	86.00	100.00
2106	Эд хогшил худалдан авах	16,482,000.00	16,482,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	16,482,000.00	16,482,000.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	313,506,000.00	313,505,512.92	487.08	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	313,506,000.00	313,505,512.92	487.08	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	313,506,000.00	313,505,512.92	487.08	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00

2.7 Аудит хийсэн Нэмэлт төсвийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөгөөр/
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	237,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	237,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	237,500.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	237,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	237,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	237,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	237,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	237,500.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын Сод эрдэм сумын Ерөнхий боловсролын сургууль нь бага болон суурь, дунд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод эрдэм сургууль нь 2022 онд “Багш бүрийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжин, суралцагчдад тулгарах бэрхшээлийг арилгах, сургалтыг зохион байгуулж байгууллагын үйлчилгээний чанарт ахиц гаргана. гэсэн зорилго дэвшүүлж 5 зорилт дэвшүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 85 хувьтай биелүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
 - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
 - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүнийг бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
 - БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
 - БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал “Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай”
 - БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал “ Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”

- БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Тус сургууль нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу 2021 оны 10 сарын 04-ны өдрийн А/54 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 5 удаа төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2022 оны 4 дүгээр сард шалгалт хийж 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын Сод эрдэм сургууль нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын Сод эрдэм сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43,266.8 мянган төгрөгөөр буюу 1.03 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	0	48,347.1	48,347.1
Авлага	0	3802.0	3802,0
Бараа материал	137,535.1	136,758.9	776.3
Үндсэн хөрөнгө	5,360,933.9	5,352,827.8	-8,106.1
Нийт хөрөнгө	5,498,469.0	5,541,735.8	43,266.8
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5.498,469,0	5,541,735.9	43,266.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5.498,469,0	5,541,735.9	43,266.8

